

МОНГОЛ ХЭЛЭНД ХЯТАД ХЭЛНЭЭС ОРСОН ЗАРИМ ҮГИЙН ТУХАЙД

ЖЯН ЧУНЬ

Хэл бол нийгмийн харилцааны гол хэрэглүүр бөгөөд нийгмийн харилцааны хөгжил дэвшлээс хэл хөгждөг. Олон улсын харилцаа урагшлан дэвших тусам олон үндэстний хэл яриа бие биедээ нэвтэрч, хөгжиж иржээ. Дэлхийн олон үндэстний хэл яриа, бичиг үсэг нь харилцан нөлөөлж, бие биедээ уусан шингэж, зээлдэн хэрэглэх гэх мэтээр харилцан урагшилж тасралтгүй хөгжиж байдаг ажээ. Дэлхийн үндэстэн болгон бүгдээрээ бусдын хэл яриа, үгсийн сангаас зээлж хэрэглэдэг. Энэ нь аливаа үндэстний баян тансаг хэл яриа, үндэстэн тус бүрийн хэл яриаг хөгжүүлэхэд маш том үүрэг гүйцэтгэдгийг харуулж байна.

Манай улсын цөөнх үндэстний хэл ярианд хятад хэлний үгсийн сангаас харилцан адилгүй төвшинд зээлж хэрэглэсэн үзэгдэл байхын сацуу мөн харьцангуй түгээмэл үгийг хятад хэлнээс зээлж ярьдаг явдал бас бий. Манай улс өөрчлөгдөн шинэчлэгдэж, бүтээн байгуулалтын үйл хэргийг дэмжин хөгжүүлснээр олон үндэстний соёл, боловсрол, эдийн засаг, амьдралын төвшин тасралтгүй дээшилж, үндэстэн бүрийн хоорондын харилцаа улам гүнзгийрч байна. Нийгмийн харилцаанд өдөр тутам нэг бус удаа бусад үндэстний хэл ярианаас зээлж, өөрийн үндэстний хэл ярианд байхгүй үгсийг нэмж оруулан хэрэглэж буй нь нийгмийн хөгжлийн шаардлага агаад нийгмийн хөгжилд зайлшгүй байх чиг хандлага юмаа. “Харилцан адилгүй үндэстний соёлын урсгал, адил төсгүй үндэстний хэл ярианд харилцан нэвтэрч тус дэм болдог. Зарим харилцан зээлдсэн үгс, заримдаа хэл яриаг үүсгэхэд нийцэн зохицдог.”¹ Ийнхүү харилцан ойлголцож, харилцан нийлэх явдлыг түргэсгэн, аливаа цөөнх үндэстэн хятад хэлнээс зээлсэн үгсийг хэрэглэж байна. Одоо монгол хэлэнд (өвөр монголчуудын хэл ярианд орсон үг бололтой

- орч.) хятад хэлнээс зээлсэн зарим үгийг судалж үзье.

Түүхийн урт хугацаанд хятад хэлнээс зээлсэн үгс:

窖 jiao-зоорь, 街 jie-зээл (гудамж), 桃儿 taor -тоор, 西瓜 xi gua- шийгуа, 黄瓜 huang-gua-гоогуа(өргөст хэмх), 白菜 baicai -байцай, 锄头 jue tou- зээтүү, 借 jie -зээл, 瓦 wa- ваар, 买卖 maimai- наймай, 辣椒 lajiao -халуун ногоо, 牙膏 yagao -оо, 麻袋 madai-маадай (уут сав), 哑巴 yaba -яаба (хэлгүй хүн), 月饼 yuebing -еэвэн, 窗户 chuanghu- цонх, 铜盆 tongpen-түмпэн, 膏药 gaoyao-гааяа(эм), 火盆 huopen-хувин, 糊涂 hutu-хуудуу, 豆腐 doufu-дүфү, 面条 miantiao-мянтууз (хэрчсэн гурил), 铺子 puzi- пүүс (лангуу, мухлаг), 台子 tazi- тааз, 牌子 paizi- пайз, 票 piao-пиу (тасалбар), 花椒 huajiao - хуажу (сайхан үнэрт чинжүү), 饽饽 bobo -боов, 剃刀 bodao-бодео (хутгаар арилгах), 灶火 zaohuo-зуух, 炮仗 paozhang- пуужин, 包子 baozi-бууз, 萝卜 luobu-лууван, 店 dian-дэлгүүр мухлаг, 板子 banzi- банз, 大布 dabu-даавуу, 酱 jiang-жан, 烟头 yantong-яндан, 烟倦 yanjuan-янжуур, 挂面 guamian-гоймон, 龙 long-луу, 元宝 yuanbao-ямбуу, 茶 cha-цай, 公社 gongshe-гүнши (нэгдэл, хамтрал), 队长 duizhan-дүйжан(багийн ахлагч), 供销社 gongxiaoshe-гунсоши(ахуй хангамжийн нэгдэл), 铁柱 tiezhu-төмөр шон, 春花 qing-hua-хаварцэцэг, 金花 jinghua-алтанцэцэг, 太平 taiping-тайван, 斤 jin-жин, 尺 chi -уртын хэмжүүр, 两 liang - хүндийн хэмжүүр, 仓库 canku-хадгалах газар, 笔 bi-үзэг, 将军 jiangjun-жанжин, 毯子 tanzi-дэвсгэр, 新 xin-шинэ, 汽灯 qideng-чийдэн, 灯 deng-дэн, 汽车 qiche-машин, 北京 Beijing-Бээжин хот гм.

Зээлж хэрэглэж буй эдгээр үгсийн сан монгол үндэстний амьдралын хүрээ, нөхцөл байдлыг тодорхойлж байна. Түүхэнд монгол үндэстний оршин тогтнох ахуй хийгээд байгалийн нөхцөл байдал, тэдгээрийн

амьдралын гол арга хэрэгсэл болох нүүдлийн мал аж ахуйд түлхэц болжээ. Мэдээжийн хэрэг, тэдний хэлний үгсийн санд дээрхи төрлийн үг байгаагүй болохоор хань үндэстэнтэй харилцан холбоо тогтоож, гэр бүл болцгоож, холилдон аж төрөхөд зээлж хэрэглэх явдал гарч, хятад хэлнээс эдгээр төрлийн үгсийг зээлдэн хэрэглэх болжээ. (хань үндэстэн бас монгол хэлнээс зээлж хэрэглэсэн үгс цөөнгүй байдаг.)

Монгол Улсад мөн түүнчлэн Оросын хилийн доторхи монгол үндэстний хэл ярианд орос хэлээс үг зээлдэн хэрэглэсэн үзэгдэл нэлээд байдаг. Тухайлбал: вокзал, вагон, марк, кино, лифт, гэрэл зургийн аппарат, харандаа, автобус, батерей г.м, мөн өнөө үед ч бас хятад хэлээс үг зээлдэн хэрэглэж байна. Байцаа, шийгуа, өргөст хэмх, гуанз, цуу, чинжүү, ханз үсэг, пайз, дэнлүү, луу, хуушуур, бууз, цай, автобус, батарей, медаль, спорт, кино, программ, академи, пальто, индүү, лифт, паспорт, сойз.

Түүхийн урт хугацааны хөгжлийн явцад олон үндэстэн хоорондоо харилцаж, холилдон нийлж, гэр бүл болцгоон, харилцан бие биеэсээ хамааралтай болж, харилцан хүлээн авч, харилцан нэвтэрч уусч байгаа нь үйлдвэрлэл, аж амьдралын арга хэлбэрээр дамжин хэрэгжиж ирсэнтэй холбоотой. Монгол үндэстэн эдгээр үйл ажиллагаанд суралцан, газар хагалах, тариа тарих, худаг гаргах, байшин барих (барилга барих), амьдралын энгийн гар ажиллагаанаас үүссэн багаж хэрэглэх (үйлдвэрлэлийн боловсруулалт), мөн түүнчлэн материаллаг нөөц, бүтээгдэхүүнээ солилцох, (хамгийн анхны наймаа хийх), “май май” гэдэг хоёр үсгийг өнөө хүртэл хэрэглэж байна.

Хүмүүс анх хэл яриагаар харилцахдаа хоёр төрлийн хэл яриаг хольж хэрэглэн, нэвтрэлцэж зорилгодоо хүрдэг байв. Жишээ нь: цай уух, боов идэх, цонхоор харах, ногооны зоорь ухах, зээтүү зээлж хэрэглэх, 6 чи (тохой) даавуу худалдаж авлаа, түмпэн дотор ус хийх, би будиллаа, маргааш хамтдаа зээлээр авъя, манай багийн даргын нэр Ли овогт, нэгдэл рүү явлаа. 1 ш шинэ үзэг авлаа, амбаарт хийв, нарийн бичгийн дарга индэр дээрээс үг хэлэв, би тантай утсаар ярилаа, Би Тунляогоос ирлээ, ажилдаа орлоо, пайз дээрхи бичгийг уншив .. г.м.

Монгол Улсын монгол хэл бичигт: ханзаар бич, пүнтүүз, байцаатай, жаахан цуу авъя, лууван авъя, луу жил, зээл (зах) гаръя, цай уу, бууз аваарай, хуушуур идээрэй, банш, пүнтүүз дуфу, жан, тог тасарчихав, вокзал, вагон, түмпэн гэж ярьж хэрэглэдэг.

Эдгээр холимог хэл, үгсийг их төлөв хэлний шууд дуудлагаар зээлж хэрэглэсэн байна. Бас зарим нь хэлний утгыг зээлж хэрэглэдэг, зарим нь утга салаалах буюу шилжсэн байдалтай байх ажээ. Эдгээр үзэгдэл өдөр тутмын хэл ярианд харьцангуй их тохиолддог. Тухайлбал: адил төстэй дуудлагаар авсан үгэнд: гуанз, дами, шийгуа, ган бийр, дянхуа, дянбао, чичэ, хуо чэ, зи синчэ, ланчү, еэвэн, түмпэн, дүфү.

Үгийн утга салаалсан буюу утга шилжсэн үгэнд: Бээжин – гэсэн нэр үг, түүний шилжсэн утга дээд, үнэтэй, дээд зэргийн гэсэн утга илэрхийлнэ. Түүний бие их гоолиг. Энэ бол хэтэрхий амттай. Маш үнэтэй эд.

Хуо зи – хятад хэлний шууд дуудлагаар хамтран ажилладаг хүн, хар ажлын хүн гэсэн утгатай, одоо бол түүний утгыг өөрчилж гаднаас ирсэн дорд хүн хэмээх болсон нь доромжилсон үг болно.

Тунсюе – хятад хэлний шууд дуудлага, үндсэн утгаар бол нэг сургуульд хамт суралцаж байсан сурагчийг хэлнэ. Улмаар утга нь сунжирч маш дотны хүн буюу сайн найзаа хэлэх болжээ.

Шуошэмо – хятад хэлний шууд дуудлагаар тухайн үед эргэлзэж асуусан асуух үг юм. Одоо бол өөрчлөгдөж юм ойлгодоггүй юмуу толгой муутай хүнийг хэлдэг.

Үй сян роу си – хоолны нэр, хятад хэл соёлд хоолыг нэрлэхээс гадна, бас ногоо хуурч хийдэг аргаар нь түүнийг монгол хэлнээ “наана, цаана” гэж орчуулж байна.

Го шань чэ - зугаацах хэрэгсэл, түүний хурдан түргэн улмаар аюумшигтай байдлыг харгалзан монгол хэлэнд “галзуу хулгана” гэж орчуулжээ. Энэ мэт жишээ маш олон гэвч энд цөөн жишээ авлаа.

Онцгой үед хятад хэлнээс зээлдсэн үгс. Хятадын соёлын нөлөөн дор, тухайн улсын дотор байдаг монгол үндэстэн болон БНХАУ-ын үндэстний хөгжлийн түүх хоорондоо нягт холбоотой. БНХАУ-ын үндэстнийг хөгжүүлэхэд, хамтдаа зовж, бэрхшээлийг даван туулж, түүхийн бүхий л үеийг цугтаа

өнгөрүүлэн, түүхийн маш урт хугацааны өөрчлөлт хийгээд хань үндэстэнтэй урт хугацаанд холбоотой байж, харилцан бие биедээ уусан нэвтрэлцэхдээ маш олон үг зээлдэн хэрэглэж иржээ. (Энд зөвхөн монгол хэлэнд хятад хэлнээс зээлж хэрэглэдэг яриаг оруулав.) Онцгой чухал үед хятад хэлнээс авч хэрэглэсэн үгийг авч үзье. Тухайлбал: БНХАУ байгуулагдсаны эхэн үед: ардын коммун, гурван талт улаан туг, ерөнхий шугам, их үсрэлт, ханган нийлүүлэх нэгдэл, хоршооллын дэлгүүр, харилцан туслах бүлэг, нарийн бичгийн дарга, бригадын дарга, боловсон хүчин, ядуу, доод, дунд тариачин, нөхөр, баян тариачин, социализм, коммунизм, коммунист намын гишүүн, коммунист залуучуудын эвлэлийн гишүүн, пионер, ган төмөр хайлуулах, өөртөө засах орон, Америкийг эсэргүүцэх, Солонгост туслах, сайн дурын арми, чөлөөлөх арми, ах дүү цэрэг дайчид, ажилчин тариачин, малчин, ван гүн язгууртан, хөдөлмөрийг өөрчлөх, баруунтан, зүүнтэн, суртлыг цэгцлэх хөдөлгөөн, “4-ийг цэвэрлэх” хөдөлгөөн, радио, бүрээ, ажилчин, тариачин цэрэг. “Үндсэн хууль”, зуух, пүүгээ, эмнэлэг, эмч г.м.

“Соёлын их хувьсгал”-ын үед: соёлын их хувьсгал, хувьсгалт хороо, урвагчид, хааныг хамгаалагчид, улаан командлагч, улаан хамгаалагч, улаан ханцуйтны тэмдэг, дурсгалын тэмдэг, цэргийн хүрэм, улаан хамгаалагчийг шалган хянах анги, тулалдааны улаан анги, том үсгийн сонин, ихээр шүүмжлэгч, уриа лоозон, их холбоо, чин сэтгэл, Ян Бань ший жүжиг, ширээний теннис, хувьсгалын өлгий, Мао удирдагчийн хэлсэн үгийн тэмдэглэл, хуучны гурван тууж, суртал ухуулгын хэсэг, сэхээтэн залуус, уулнаас буух, ард түмний төлөө үйлчлэх, хувьсгалт бүлэг, хөрөнгөтний замаар замнах, гэмт хэргийн бүлэг, таван улаан, долоон хар, ангийн тэмцлийн хөтөлбөр, “4-ийн бүлэг”, “самууны үе”, дугуй, автомашин, бугуйн цаг, хүлээн авагч, хүнсний карт, даавууны карт, аж үйлдвэрийн хувьцаа, ноосон хивс, ноолууран хувцас, ноосон материал, дулаан сэнс гм.

Өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлж байх үед: өөрчлөлт шинэчлэл, нээлттэй байх, “дөрвийг орчин үежүүлэх”, онцгой бүс, хувийн аж ахуйтан, арван мянгат

өрх, хариуцлагын тогтолцоо, амьдралаа дээшлүүлэх, ажилд орох, ажлаас халагдах, эдийн засаг, хууль зүй, хуульч, аюулаас хамгаалах, үйлчлэгч, менежер, ТУЗ-ийн дарга, хөтөлбөр, толгойлогч, удирдлага, эрхэмсэг ноён, профессор, захиргааны ажил, албан хаагч, зочид буудал, зоогийн газар, компани, телевизийн хороо, телевизийн цамхаг, банк, зээл, улсын үнэт цаас, хувьцаа, сугалаа, даатгалын компани, усан бассейн, бие бялдаржуулах төв, бооний худалдаа, хийжүүлсэн ундаа, бордоо, зайрмаг, телевиз, дуу хураагуур (магнетофон), хуурцаг (кассет), үүрэн телефон, гар утас, “да гэ да” (пейжер), угаалгын машин, хөргөгч, тоос сорогч, сэнс, хийтэй баллон, жинсэн өмд, хонины ноосон цамц, банзал, савхин хүрэм, цахилгаан тогоо, богино долгионы шарах шүүгээ, агааржуулагч, ус татагч, компьютер, тооны машин, усанд хөвөгч, хувилах машин, хэвлэх машин, компакт диск, уян диск, хатуу диск, пентиум, алсын удирдлага, хянагч дуран (камер), агаарын тээврийн хэрэгсэл, түрээсийн машин (такси), талхны машин, байгалийн хий, сувилалын газар, дээд шалгалт, шалган судлах, үйлдвэр худалдаа, татвар, гоосайхны газар, аялал жуулчлал, интернет кафе, мессеж, биеийн тамир, спортын хороо, оюутан, аспирант, лекц, эдийн засгийн нээлттэй бүс, төлөвлөгөөт төрөлт, ханиад, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, байгаль орчныг хамгаалах, худалдааны танхим, үзэсгэлэн-яармаг, зардал гм.

Өнөөгийн Хятад улсад дээд зэргийн дэвшилтэт нарийн шинэ техник технологийг хөгжүүлж, шинжлэх ухааны мэдлэгийг өргөжүүлэн, шинжлэх ухаан, техник болон мэдээллийн хөгжлийг хурдыг түргэтгэснээр шинжлэх ухаан техникийн хэл, мөн түүнчлэн шинэ цагийг илтгэсэн шинэ нэр томъёо, үгсийн санд их хэмжээгээр цутган орж ирж байна. Эдгээр үг хэллэгийн зарим нь монгол хэлэнд орчуулахад сайн бууж өгөхгүй буюу харилцан тохирох, орлуулах үг байдаггүй, эсвэл гэнэт бий болсон үг байдаг. Иймээс үгийг шууд үндсээр нь авч хэрэглэдэг. Түүхийн явцад нийгэм өөрчлөгдөж, цаг улиран элэгдэж, эдгээр үгсийн сангийн стандарт аажмаар түүхийн тавцнаас арчигдан хаягдах болно. Тухайлбал онцгой үеийн

онцгой үгсийн сан бий болохдоо ч түргэн, устаж үгүй болохдоо ч амархан онцлогтой байдаг.

Монгол үндэстэн хятад хэлнээс үг зээлж хэрэглэхдээ, эхлээд хуулбарлаад, хэсэг хугацааны хооронд авч хэрэглээд, дараа нь үндсэн утгын дагуу загваржуулах буюу тухайн үндэстний хэлний илэрхийллийг өөрчлөн хэрэглэдэг. Эдгээр үзэгдэл нь эхэндээ аман ярианы хэлбэрээр нийтэд тархдаг. Монгол үндэстний хэл шинжлэлийн эрдэмтэн С.Рэнчин: “Бусад үндэстний баялаг үгсийн сангаас, ялангуяа хань үндэстний баялаг үгсийн сангаас чухаг үгсийг авч сандаа оруулан хэрэглэж буй өөрийн хэлний үзэгдэл нь зөвхөн тухайн үндэстний хэлийг сулруулах бус хөгжүүлэн баяжуулах төдийгүй уг үндэстний хэл, үг ярианы бүтцийг боловсронгуй болгох олон талын ашигтай. Эдгээр нь түүхэн хөгжлийн явцад батлагдаж ирсэн билээ.”² гэжээ. Хятад хэлнээс зээлдэж монгол хэлэнд орсон зээлдмэл үгс томоохон хэсгийг эзэлдэг бөгөөд энэ нь монгол хэлийг баяжуулан хөгжүүлэх чухал үндсэн хэсгийн нэг юм. Монгол үндэстэн урт хугацаанд хятад хэлнээс үг зээлэн хэрэглэхдээ аажимдаа эдгээр үгийг өөрсдийн хэм хэмжээндээ оруулан хэрэглүүлэх, өөрийн үгсийн сандаа нэвтрүүлэх улмаар зээлдмэл цогц үг болгон

(гадаад хэлнээс орж ирсэн үг), ном бичих дүрмийг тогтоодог байна. Энэ нь монгол хэлийг хөгжүүлэн баяжуулах тухайд, монгол хэлний үгсийн санг өргөжүүлэхэд орчин үед болон түүхэнд чухал ач холбогдолтой юм.

Их хэмжээгээр үг зээлж хэрэглэснээр хятад дахь монгол үндэстний болон бусад үндэстэн, ялангуяа хань үндэстэнтэй хоорондоо хэл яриа, соёлын талаар харилцан ойлголцох явдлыг гүнзгийрүүлэн өргөжүүлж, өөрийн соёл болоод хэл яриагаа илэрхийлэн таниулах, илтгэх чадварыг нэмэгдүүлсэн нь хятадын соёл болон дэлхийн соёлын хоорондын зай багасгахад, тухайн үндэстний шинжлэх ухаан соёлын төвшинг дээшлүүлэн түгээхэд маш том үүрэг гүйцэтгэж байна.

Ишлэл зүүлт:

1. Чэнь Юан. Хэл ба хүн. Шань у хэвлэлийн газар. 2003

2. С.Рэнчин. Монгол хэл соёлын түүх. (монгол хэлээр) ӨМ-ын Их сургуулийн хэвлэлийн газар. 1959.

“发展中国家社会改革研究” 乌兰巴托, , 2004.8 сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийг хятад хэлнээс орчуулсан Д.Өүлэн-Үжин ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан